

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
 Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

2023.12.27

Байгууллагын нэр:

Цагдаагийн ерөнхий газар

Нэгжийн нэр:

Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн
байгууллага

Албан тушаалтны нэр:

Хэсгийн байцаагч

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

ТТ-8

Ажлын цаг:

8 цаг

Ажлын байрны албан ёсны нэршил:

Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн
байгууллагын байр

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Байгалийн гамшиг, гол түймэр, хүн, малын
гоц халдварт өвчин гарсан, гэнэтийн болон
бусад аюул тохиолдсон, нийтийн эмх
замбараагүй байдал үүссэн, террорист
халдлага, онц болон дайны байдал
зарласан, онц ноцтой гэмт хэрэг үйлдэгдсэн
зэрэг зайлшгүй тохиолдолд өндөржүүлсэн
бэлэн байдалд ажиллах.

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ.

Албан тушаалын зорилго:

Хариуцсан хорооны нутаг дэвсгэрт гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам
хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиг
үүргийг гүйцэтгэх, нийтээр дагаж мөрдөх хууль тогтоомжийг сахиулах, удирдлагаас өгсөн үүрэг,
чиглэлийг хэрэгжүүлж ажиллах.

Албан тушаалын зорилт:

- Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг
үүргийг хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах, үр дүнг тайлагнах.
- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл
ажиллагааг хэрэгжүүлэх, үр дүнг тайлагнах.
- Хууль тогтоомж, дүрэм, журмаар хүлээлгэсэн ажлын байрны зорилгод нийцсэн бусад чиг
үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах-Т, Хариуцан Гүйцэтгэх-Г, Хянах-Х, Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	<p>1.1 .Хариуцсан хорооны нутаг дэвсгэрт гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг танилцуулах;</p> <p>1.2. Цагдаагийн байгууллагад хуулиар харьялуулсан зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авч, зөрчлийн хэрэгт хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулж, шалган шийдвэрлэх;</p> <p>1.3. Гудамж, талбай болон нийтийн эзэмшлийн бусад газарт эргүүл хийх, байнгын болон түр ажиллагаатай хянаж-нэвтрүүлэх цэг ажиллуулах, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг, бусад арга, техник хэрэгсэл ашиглан хяналт тавих;</p> <p>1.4. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, Галт, зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон химиин хортой бодис, хар тамхи, мансууруулах бодис, согтууруулах ундааны хууль бус худалдаа, үйлдвэрлэл, гэрээт харуулын болон хувийн хамгаалалтын үйл ажиллагаанд хяналт тавих, Насанд хүрээгүй хүнийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахтай холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;</p> <p>1.5.Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хараа хяналтгүй болсон хүүхэд, гээгдэл эд хөрөнгө, алдуул малыг бүртгэх, түүнтэй холбоотой асуудлыг шийдвэрлэх, эрх бүхий байгууллага, албан тушаалтны даалгасан сураггүй алга болсон хүнийг эрэн сурвалжлах, баривчлах;</p> <p>1.6.Чиг үүргээ хэрэгжүүлэх явцад илэрсэн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг арилгуулах, тэдгээрийг гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор иргэн, хуулийн этгээдэд шаардлага, сээрэмжлүүлэг өгөх, биелэлтийг нь хангуулах;</p> <p>1.7. Хорихоос өөр төрлийн ял шийтгэлтэй болон хорих ял эдлээд суллагдсан зарим хүмүүст захиргааны хяналт тавих үйл ажиллагааг хэрэгжүүлэх;</p> <p>1.8. Хариуцсан нутаг дэвсгэрт хорио цээр, хязгаарлалтын дэглэм сахиулах, нийтийн эмх замбараагүй байдал үүссэн, террорист халдлага гарсан, онц болон дайны байдал зарласан үед олон нийтийн аюулгүй байдлыг хангах, жагсаал, цуглааныг албадан тараах ажиллагаа, нийтийг хамарсан арга хэмжээний үеийн хамгаалалтад ажиллах, удирдлагыг мэдээ,</p>	Хуульд заасан чиг үүргийн хэрэгжилт хангагдаж, ажлын үр дүн бодитой үнэлэгдэж, үйл ажиллагаа сайжирна.	Г Г Г Г Г Г Г Г Г

	<p>мэдээллээр хангах, өгсөн үүргийг хэрэгжүүлэх, үр дүнг танилцуулах;</p> <p>1.9. Сум, баг, хороо /эргүүлийн/ цагдаа, олон нийтийн цагдааг мэргэжил, арга зүйгээр хангаж хамтран ажиллах, сургаж дадлагажуулах, объектын судалгаа, ажлын тооцоо, тэмдэглэлтэй байж, цаг ашиглалт, ажлын үр дүн, сахилга хариуцлагыг хариуцах;</p> <p>1.10.Хууль тогтоомж, дээд шатны байгууллага, албан тушаалтан, удирдлагаас гаргасан шийдвэр, үүрэг, ажлын чиглэл, албан даалгавар, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр албад, бусад байгууллагатай хамтран зохион байгуулах;</p> <p>1.11.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахдаа тухайн нутаг дэвсгэр дэх төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж байгууллага, иргэдийн туслалцаа хамтын ажиллагаанд түшиглэнэ. Хийсэн ажлын тайлангаа иргэд, олон нийтэд хагас бүтэн жилээр тавьж, санал шүүмжлэлийн мөрөөр тодорхой ажил зохион байгуулах;</p> <p>1.12.Сум, баг, хорооныхоо эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлыг судалж, гэмт хэрэг, зөрчил гарч болзошгүй газар орон, сэжигтэй этгээдүүдийг хяналтдаа авч, шалгах;</p> <p>1.13.Хариуцсан нутаг дэвсгэрт үүрэг гүйцэтгэж байгаа эргүүлийн үйл ажиллагаанд өдөр бүр хяналт тавьж, нутаг дэвсгэрийн нөхцөл байдалд уялдуулан эргүүлийн чиглэл, маршрутад санал өгч, хамтран ажиллах;</p> <p>1.14.Архидан согтуурахтай тэмцэх, гэр булийн хучирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах ажилд оролцож үр дүнг танилцуулах.</p>	Г	Г	Г	Г	Г
	<p>2.1.Баг, хорооны Засаг даргатай гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийтээр дагаж мөрдөх дүрэм, журмын хэрэгжилтийг хангуулах чиглэлээр доорх хэлбэрээр хамтран ажиллана. Үүнд:</p> <p>а/Хууль, тогтоомж, дээд шатны байгууллагын тогтоол шийдвэрийг сум, баг, хорооны иргэдэд мэдээлэх, түүнийг биелүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтэд хяналт тавих, үзлэг, шалгалт Охийхэд туслалцаа дэмжлэг үзүүлнэ;</p> <p>б/Нутаг дэвсгэрийн хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах зөвлөлийн үйл ажиллагаанд оролцно;</p> <p>в/Тогтоосон өдөр, цагийн хуваарийн дагуу иргэдийн санал, өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх, тайлангаа иргэдэд тавихад оролцно;</p>	Хуулийн хэрэгжилт хангагдана.			Г	Г

2 дугаар зорилтын хүрээнд	<p>г/Сум, дүүрэг /баг, хороо/-ийн Засаг даргын эрх хэмжээнийхээ дотор хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан захирамжийг хэрэгжүүлэхэд оролцно;</p> <p>д/Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хамтарсан багт ажиллаж, гэмт хэрэг, зөрчилтэй шинжтэй мэдээллийг хүлээн авч, шаардлагатай тусламж, зөвлөгөө өгөх, эрх, үүргийг нь тайлбарлаж, үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээллийг бичгээр өгөх, хохирогчийн эрхийг хангах арга хэмжээ авах, хүчирхийллийг таслан зогсоон зорилгоор бусдын орон байранд нэвтрэн орох, шалгах, аюулын зэргийн үнэлгээ хийж, зэрэг өндөртэй, эсхүл хүүхэд хүчирхийлэлд өртсөн бол нийгмийн ажилтанд мэдэгдэх, хохирогчийг нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байранд хүргэх, боломжтой бол төрөл, садан, ойр дотнын хүний түр хамгаалалтад өгөх, хүчирхийлэл үйлдэгчид хүчирхийлэл үйлдэх, согтууруулах ундаа хэрэглэхийг зогсоохыг шаардах, албадлага хэрэглэх, шаардлагатай бол баривчлах, зэвсэг, зэвсгийн чанартай зүйлийг хураан авах ажиллагааг хийж, бүртгэл хөтөлж, мэдээллийн нэгдсэн сан бурдуулна.</p> <p>2.2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд иргэдийн сайн дурын үүсгэл санаачилгыг өрнүүлэх, бусад тэргүүн туршлагыг судалж нэвтрүүлэх;</p> <p>2.3. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр нутаг дэвсгэрийн иргэдэйтэй хамтран ажил зохион байгуулна.</p>	Г	Г
3 дугаар зорилтын хүрээнд	<p>Ажлын байрны зорилгын хүрээнд явуулах бусад үйл ажиллагаа:</p> <p>1.Хууль тогтоомж, дүрэм, журмаар хүлээлгэсэн ажлын байрны зорилгод нийцсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.</p> <p>2.Шууд удирдах албан тушаалтнаас өгсөн хууль ёсны үүрэг даалгаврын биелэлтийг хангах</p> <p>3. Албан хэрэг хөтлөлт, архивын журмыг өдөр тутмын үйл ажиллагаандaa мөрдөж ажиллах</p> <p>4.Төрийн алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлж, байгууллагын ажилтнууд болон харилцагч, үйлчлүүлэгчид иргэдтэй зөв боловсон харьцах ёс зүйн зөрчил дутагдал гаргахгүй байх</p> <p>Шударга ёсны шалгуурыг хангах, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх талаар:</p> <p>1.Авлига, хүнд суртлаас ангид байж хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн, шударга ёсыг эрхэмлэн “Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг чанд сахих;</p> <p>2.Явцуу эрх ашиг сонирхлоос татгалзаж, цагдаагийн байгууллага, албаны нийтлэг эрх ашиг сонирхлыг эрхэмлэн ажиллах.</p>	<p>Ажлын байрны зорилго, зорилт хангагдаж, цагдаагийн алба хаагчийн хуулиар хүлээлсэн нийтлэг чиг үүргийн биелэлт хангагдана.</p>	Г

III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	-Дээд боловсролтой, бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй	
Мэргэжил	-Эрх зүй /0421/, Аюулгүй байдал судлал /103901/, Иргэн, өмч хөрөнгө хамгаалал /1032/;	
Мэргэшил	-Албан тушаалын мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн байх.	
Туршлага	Цагдаагийн байгууллагад 3-аас доошгүй жил үр бүтээлтэй ажилласан байх.	
Үр чадвар	Дүн шинжилгээ хийх	-Мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх -Гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах -Судалгааны ерөнхий арга зүйн мэдлэгтэй
	Асуудал шийдвэрлэх	-Өөрийн чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулж, хариуцах -Шаардлагатай асуудлаар судалгаа хийж, дүнг хариуцах
	Багаар Ажиллах	- Өөрийн мэдлэг үр чадвар, өөрт байгаа мэдлэгийг баг хамт олонтойгоо хуваалцаж хамтран ажиллах. - Бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох.
	Бусад	

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр: Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах тасгийн дарга	Бусад харилцах субъект: Шууд харилцах: Хариуцсан асуудлаар бусад яам, агентлагийн албан тушаалын адил болон түүнээс доosh зэрэглэлтэй албан тушаалтан.
Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр, тоо:	Шууд бус харилцах: Төрийн бус байгууллага, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, олон улсын байгууллага /Эдгээртэй харилцахдаа Цагдаагийн албаны тухай хууль, бусад хууль тогтоомж, үйл ажиллагааны журмын холбогдох заалтыг баримтална/.

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан: Албан тушаал: ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭД ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА  T. ГАНЗОРИГ	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр: Байгууллагын нэр: Шийдвэрийн огноо: Дугаар:
2023 оны 11 дугаар сарын 22-ны өдөр	

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр: ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

Шийдвэрийн огноо: 2023 оны 12 дугаар сарын 27. өдөр.

Дугаар: 1/101

ДАРГА,

ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Т.СҮХБОЛД

2023 оны 12. дугаар сарын 27.-ны өдөр

Танилцсан:

Албан тушаалтан:

20... оны дугаар сарын-ны өдөр